



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 304

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.1, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Радио телевизийн үндэсний сүлжээ” улсын төсөвт үйлдвэрийн газрын харьяа салбар нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 нэрийн, 4,242,641.00 (дөрвөн сая хоёр зуун дөчин хоёр мянга зургаан зуун дөчин нэгэн) төгрөгийн балансын үнэ, 4,155,141.17 (дөрвөн сая нэг зуун тавин таван мянга нэг зуун дөчин нэгэн төгрөг арван долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Радио телевизийн үндэсний сүлжээ” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Цагаанхүүд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг зориулалтын дагуу ашиглах;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4 Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

000486



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 05 дугаар сарын 12 ны өдрийн
30 дугаар тогтоолын хавсралт

"РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ХАРЬАА САЛБАР, НЭГЖИЙН

АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг	Нэгж, салбар (аймаг)
1	Нөүтбүүк I5	2015	ш	1	1,750,000.00	1,662,500.17	87,500	Баян-Өлгий аймаг дахь салбар
2	Буу	2004	ш	1	252,976.00	252,976.00	-	Баян-Өлгий аймаг дахь салбар
3	ТВ антенн	1991	ш	1	271,350.00	271,350.00	-	Говь-Алтай аймаг дахь салбар
4	Хиймэл дагуулын антенн	2005	ш	1	657,915.00	657,915.00	-	Говь-Алтай аймаг дахь салбар
5	Торон хашаа	2018	м	1,496	1,310,400.00	1,310,400.00	-	Хөвсгөл аймаг дахь салбар
Нийт дүн					4,242,641.00	4,155,141.17		
					(дөрвөн сая хоёр зуун дөчин хоёр мянга зургаан зуун дөчин нэгэн төгрөг)	(дөрвөн сая нэг зуун тавин таван мянга нэг зуун дөчин нэгэн төгрөг арван долоон мөнгө)	(наян долоон мянга таван зуун)	